

## ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 09 сарын 08-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 08 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 07 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн ээлжит бус 5 дугаар хуралдаан цахим болон танхимаар 08 дугаар сарын 01-ний өдөр, аймгийн ИТХ-ын ээлжит бус 6 дугаар хуралдаан оны 08 дугаар сарын 04-ний өдөр хуралдаж Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл батламжлах тухай, Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтийн тухай, “Нээлттэй Төв аймаг” хөтөлбөр батлах тухай 4 асуудал тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.
2. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хот суурин, үйлдвэрлэл үйлчилгээ дэд бүтцийн хөгжлийн хорооноос Зуунмод сумын Номт 1 дүгээр багийн иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу 18 дугаар байрны нөхцөл байдалтай танилцаж холбогдох дүгнэлтийг аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласан.
3. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Зам тээврийн осол, хэргийг бууруулах хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэснээс үүдэлтэйгээр үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчил, эсдлийг бууруулах зорилгоор аймгийн цагдаагийн газарт 10 сая төгрөгийн санхүүжилтээр согтолт тодорхойлох 10 ш тандагч багаж олгох ажлыг зохион байгууллаа.
4. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороод 08 дугаар сарын 02-ны өдөр тус тус хуралдаж Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл батламжлах тухай, Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтийн тухай асуудал хэлэлцэн дүгнэлт гаргаж ажилласан.
5. Аймгийн ИТХ, ажлын албанд 08 дугаар сард 10 бичиг, 8 өргөдөл хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

### ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг 08 дугаар сарын 07, 28-ны өдрүүдэд танхимаар зохион байгуулж, хэлтэс агентлаг, сумдын удирдлагад үүрэг даалгавар өгөв. Төв аймаг байгуулууллагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 90-ээс дээш настнуудад гарын бэлэг, сумдын удирдах ажилтан багийн Засаг дарга нарт 100 жилийн ойн бэлэг хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

### “ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ”-ИЙН ХҮРЭЭНД:

8 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **600-аад** төрлийн үйлчилгээг **5500 гаруй** иргэнд, өдөрт дунджаар **230-270** иргэнд хүргэн үйлчилсэн.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд **1112** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **610** лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмжийг, төрийн үйлчилгээг цахимаар авч болох тухай мэдээ мэдээллийг **168** иргэнд хүргэж ажилласан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **9** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn), Газрын мэдээллийн нэгдсэн сангийн

[www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn), Аймгийн албан ёсны веб сайт [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), Аймгийн статистикийн хэлтсийн [www.nso.gov.mn](http://www.nso.gov.mn) сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаар дамжуулан нийт 141 иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан 50 иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авсан.

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Ногоон бүсийн айл өрх, амралтын газар, жуулчны баазын барилга, байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”-ийн хүрээнд Төв аймгийн Аргалант, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Эрдэнэ сумдад үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 24-өөс 08 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Зуунмод сумын үерийн далан шуудуунд 2 удаа үзлэг шалгалт зохион байгуулж Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдэл хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 37 ногоон бүсийн иргэн, хуулийн этгээдийн барилга, байгууламжийг хамруулан нийт 26 зөрчил дутагдлыг илрүүлж, зөрчил дутагдлуудыг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 3 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газрын удирдлагууд болон ажилчдад танилцуулж, Галын аюулгүй байдлын тухай хуулиудад заагдсан эрх үүрэг, илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Боловсролын байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”-ийн хүрээнд Төв аймгийн Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж буй сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2023 оны 08 дугаар сарын 14-30-ны өдрүүдэд зохион байгуулав.

Хяналт шалгалтаар 12 сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжийг хамруулан нийт 98 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 23-ыг арилгуулж, бусад 75 зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлж, шалгалтын дүнг танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар нийт 20 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж аюулт үзэгдэл, осол гарч болзошгүй 230 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 46 зөрчил арилгуулж холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 14 аж ахуй нэгж, байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгосон. Барилга байгууламж шинээр ашиглалтад оруулах, байнгын ашиглалтад авах улсын комисст 3 удаа оролцсон.

Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “ЦҮЙ ВАНГ ИНВЕСТ” ХХК-ийн тэсрэх материалын агуулахын гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд анхан шатны хяналт хийж Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буудлын Шатахуун хангалтын албаны ажилтан, алба хаагчдад 4 цагийн танхимын болон дадлага сургалт зохион байгуулж 68 хүнийг хамрууллаа.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 32 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа. Мөн байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 2 төрлийн постер 3 төрлийн видео бичлэгийг байршуулсан.

-Объектын гал түймэр-6 (Алтанбулаг сум, Батсүмбэр сум, Мөнгөнморьт сум, Зуунмод суманд-2 удаа, Өндөрширээт сум),

-Үер-3 (Алтанбулаг сум, Баянцагаан сум, Эрдэнэсант сум),

-Мал, амьтны гоц халдварт өвчин-2 Баянжаргалан (Хонь цэцэг өвчин хязгаарлалтын дэглэм), Мөнгөнморьт (Боом),

-Шаварт суусан-1 (Баянчандмань сум),

-Эрэн хайх ажиллагаа-2 (Батсүмбэр сум, Улаанбаатар) нийт 16 дуудлага, мэдээлэл хүлээн авч, гал түймэр унтраах, эрэн хайх аврах, хор уршиг арилгах үйл ажиллагаанд Онцгой

байдлын газраас давхардсан тоогоор 27 алба хаагч, 5 техник, эрэлч нохой-1, орон нутгийн иргэд-93, 17 техниктэй аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн.

### **ГУРАВ:ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:**

Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүх, сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх хуралд аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 3 удаагийн шүүх хуралд оролцлоо.

Төв аймгийн Цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн 5 иргэн, 1 аж ахуйн нэгжид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 2000000 төгрөгийн арга хэмжээ авч прокурорын хяналтад хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/586 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг дарга, ЗДТГ, болон тус сумын нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхөрлөлийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” холбогдох дүрэм, норм, стандартын хэрэгжилтэд 2023 оны 08 дугаар сарын 07-ний өдөр хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар Заамар суманд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан Зэумар замбала нөхөрлөл нь тус талбайд үйл ажиллагаа явуулахдаа 3500 см<sup>3</sup> дээш багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий Dooson DX500LC маркийн экскаватор, механизмыг ашигласан зөрчилд улсын байцаагчийн 06/30-06/040-01 дугаартай актаар үйл ажиллагааг зогсоож ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал арилгасан тул тус нөхөрлөлийн үйл ажиллагааг улсын байцаагчийн 06/30-06/040-02 дугаартай актаар сэргээж, илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгээр 1500 нэгжтэй тэнцэх буюу 1500000 төгрөгийн арга хэмжээ авч ажилласан.

#### **ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР**

Тус төрийн архивын тасаг нь архивын эх баримтаас байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу 106 иргэний хүсэлтийг хүлээн авч 556 хуулбар хувь олгож, 53 лавлагаа олгож орон нутгийн төсөвт 1,089,000 мянган төгрөгийг орууллаа.

Нэг хөмрөгийн 147 хадгаламжийн нэгжийн 1580 хуудас баримтын 1432 заалтын тоо, 1432 тушаалын тоо, 8697 хүний нэрийг мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивэж, 1 хөмрөгийн 1432 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 1432 заалтын 1580 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр 2 хөмрөгийн 18 хадгаламжийн нэгжийг хүлээж авч хүлээн авч, бүртгэлээ.

#### **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 68381 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138979 газар өмчлөх эрхийн 56133 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 901 /8 сард хүлээн авсан мэдүүлэг /901/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 2023 оны 8-р сарын байдлаар нийт 47993390 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 167751819 төгрөг, тэмдэгтийн хураамжаас 6309839 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 3043 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 217 нэмэлт өөрчлөлт, шинээр 126 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 2, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 52 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 82 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 120 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого нийт 51466000 төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

#### **ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2023 оны 08 дугаар сард 448 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 99 хэргээр буюу 18 хувиар буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 52,1 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,4 хувиар өссөн байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-5, шүүхээр баривчлагдсан-37, согтуугаар саатуулагдсан-4, ар гэрт нь 9 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 55 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Шүүхээр баривчлагдаж, хугацаа дуусаж гарсан 39 иргэний төлбөр 2,175,000 төгрөг, эрүүлжүүлэгдсэн 5 иргэний 20750 төгрөг, нийт 2,195,750 төгрөгийг төрийн сангийн 100140012001 тоот дансанд бүрэн тушаасан.

Тус цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас 2023 оны 8 дугаар сард олон нийтийг хамарсан 2 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 12 алба хаагч, 5 автомашин, 12 тусгай хэрэгсэл, 3 холбооны хэрэгсэл, ашиглаж 26 цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан.

Төв аймгийн Мөнгөнморьт сум Байдлаг 2-р баг Нагшуур, Харзтай, Хар хошууны үзүүр, Тэмээн бөхөн гэх газруудад намаржиж байгаа 8 айлын малаас малын гоц халдварт боом өвчин илэрч 43 тооны үхэр хорогдсон. Тус сумын засаг даргын А/207 тоот захирамжаар 21 хоногийн хорио цээрийн дэглэм тогтоож хяналтын түр 2 постыг байгуулж, Цагдаагийн газраас 2 алба хаагч, 1 тээврийн хэрэгсэлтэй, Засаг даргын тамгын газраас 6 алба хаагч, 1 тээврийн хэрэгсэлтэй ажиллаж байна. Нэмж үхэр хорогдоогүй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 5699 зөрчил илрүүлж, Монгол улсын Зөрчлийн тухай хууль ийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 5 дахь заалтуудыг зөрчиж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 86 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 57 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон 29 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчилуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 42 жолоочийг илрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэсэн.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5571 жолоочийг 131,496,000 /нэг зуун гучин нэгэн сая дөрвөн зуун ерэн зургаан мянга/-н төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 128 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

#### **ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

Криминалистикийн шинжилгээ-90, магадлан шинжилгээ-163, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-339, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-774, гарын хээний санг дардсаар баяжуулсан-204, мөрөөр баяжуулсан-47, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-519, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-163, гистологийн шинжилгээ-163 хийгдлээ.

#### **ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
08-р сар	309	349	36	622	260	362	41.8
	4857937.6	3997050.4	459628.3	8395359.7	1963598.9	6431760.8	

#### **ДӨРӨВ:ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР:**

*Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:*

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дахь заалтын дагуу хяналт-шинжилгээ хийхэд

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 138 заалтын хэрэгжилтийн явцыг 2023 оны 7 дугаар сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан ([www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn))-аар тайлагнаж ажиллалаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо	21
Үр дүнтэй	100% <a href="#">19</a>

Тодорхой үр дүнд хүрсэн	90%	-
	70%	-
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	<u>1</u>
	30%	-
Үр дүнгүй	0%	-
Хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	<u>1</u>
(Хүрсэн түвшин - Суурь түвшин) / (Зорилтот түвшин - Суурь түвшин) * 100	100>...>90	-
	90>...>70	-
	70>...>50	-
	50>...>30	-
	30>...>0	-
Хэрэгжилтийн дундаж		97.5%

#### Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		41
Бүрэн хэрэгжсэн	100%	<u>30</u>
Хэрэгжих шатанд	70%	<u>6</u>
Хэрэгжилт хангалтгүй	30%	<u>3</u>
Хэрэгжээгүй	0%	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	<u>2</u>
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй		90%

#### Санхүүгийн хяналт, шалгалтын талаар:

2023 оны 8 дугаар сарын 31-ны байдлаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны төлөвлөгөөний дагуу сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Баянцагаан сумын ЭМТ, Эрдэнэсант “АЗЗА” ТӨХК-ы 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж 620,836.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 29,073.3 мянган төгрөгийн зөрчилд Улсын ахлах байцаагчийн акт, 591,762.9 мянган төгрөгийн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллалаа.

Санхүүгийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Шуудан үйлчилгээний газар, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Статистикийн хэлтэс, Зуунмодны политехник коллеж, Мал эмнэлэгийн газар, Ойн ангиуд, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Баянцаган, Сэргэлэн, Эрдэнэсант, Өндөрширээт, Дэлгэрхаан, Батсүмбэр, Борнуур, Баянчандмань сумдын төсөвт байгууллагуудад, аймгийн нэгдсэн эмнэлэг, Сангийн яамны нэгдсэн удирдамжийн дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж 1,786,037.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 131,001.4 мянган төгрөгийн зөрчилд санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 1,655,035.7 мянган төгрөгийн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллалаа.

Төв аймгийн Засаг дарга бөгөөд дотоод аудитын хорооны даргын батласан удирдамжийн дагуу БЗОСК, ОНӨГазар, Авто тээврийн төв, Татварын хэлтэсийн 2021-2022 оны үйл ажиллагааны баримтуудад санхүүгийн хяналт шалгалт хийгдэж байна.

Эхний 8 сарын байдлаар: Нийт илрүүлсэн зөрчил 2,406,873.3 мянган төгрөг Үүнээс:

- СХШУ-ын ахлах байцаагчийн акт 160,074.7 мянган төгрөг
- СХШУ-ын ахлах байцаагчийн албан шаардлага 2,246,798.6 мянган төгрөг

Өмнөх онуудын актын үлдэгдэл 190,473.4 мянган төгрөгийн актын үлдэгдэлээс 40,285.1 мянган төгрөг барагдаж, 150,188.3 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

## **ТАВ:ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТАЛААР**

### Төсвийн орлогын талаар:

Орлогын төлөвлөгөө 2023 оны 07 дугаар сарын байдлаар орон нутаг 16,547,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 24,550,5 сая төгрөг төвлөрүүлж 148,4 хувьтай, 8,002,6 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 3,573,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,045,5 сая төгрөг төвлөрүүлж 113,2 хувьтай, 472,3 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлтийг нийт 8,917,8 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 138,4 хувьтай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөг биелүүлсэн 7 сум байна. Үүнд: Архуст, Борнуур, Лүн, Сүмбэр, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Заамар, Мөнгөнморьт, Өндөрширээт, Угтаал, Зуунмод зэрэг 13 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Аргалант, Батсүмбэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Сэргэлэн зэрэг 6 сум байна. 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан Баянхангай сум байна

### Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Аймгийн төсвөөс 2023 оны 07 дугаар сарын байдлаар нийт 32,776,6 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн төсвийн байгууллага болон 27 суманд олгосон.

### Зарлагыг салбараар авч үзвэл:

Боловсрол, шинжлэх ухааны байгууллага 6,171,2 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллага 582,4 сая төгрөг

Нийтийн ерөнхий үйлчилгээ 25,198,2 сая төгрөг

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд 20,122,3 сая төгрөг, нийт 52,047,1 сая төгрөгийн зарлага гаргаад байна.

### Өр, авлагын талаар:

2023 оны 07-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 293,1 сая төгрөгийн авлага, 609,3 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 295,5 сая төгрөг буюу 48,2 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 4,2 сая төгрөг буюу 0,7 хувь нь цалингийн өглөг, 70,9 сая төгрөг буюу 11,6 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 47,7 сая төгрөг буюу 7,8 хувь нь цэвэр, бохир усны зардлын өглөг, үлдсэн 159,2 сая төгрөг буюу 31,8 хувийг бусад өр эзэлж байна.

## **ЗУРГАА: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

### **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

*Хөрөнгө оруулалт, барилга захиалагч, хяналтын чиглэлээр:*

- Нэгдсэн А болон Б блокийн дээврийн засварын ажлын тендерийг зарласан
- Нийтийн орон сууцны 18–р байрны халаалтын босоо болон төв магистраль шугам сүлжээг шинэчлэх ажлын тендерийг зарласан.

*Хот байгуулалтын чиглэлээр:*

- Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2023 онд 51 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 1 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.
- Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршлийг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд 116 зураг төсөл зөвшилцсөн. Энэ сард 17 зураг төсөл батлаад байна.

*Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл ашиглалтад оруулах үйл ажиллагааны чиглэлээр:*

- Барилга эхлүүлэх зөвшөөрөл олгох ажлын хүрээнд нийт 2023 онд 63 зөвшөөрөл олгосноос энэ сард 10 зөвшөөрөл олгоод байна.
- Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд нийт 2023 онд 81 барилга байгууламжийг ашиглалтад оруулсанаас энэ сард 33 барилга байгууламжийг ашиглалтад оруулаад байна.

*Барилга техникийн хяналтын чиглэлээр:*

- Бүрэн сумын бага сургуулийн өргөтгөлийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллалаа.
- Таван толгой түлш ХХК-ны үйлдвэрийн А болон Б блокийн барилга дээр байнгын ашиглалтанд оруулах улсын комисс холбогдох үүрэг даалгавруудыг өгч ажилласан.
- Аймгийн засаг даргын тамгын газрын өргөтгөлийн барилгын дотор халаалт цэвэр ус болон ариутгах татуургын шугам сүлжээний шинэчлэлийн ажил, дотор засал, дотор цахилгааны засварын ажлууд бүрэн дуусгаж комисс ажилласан
- Улсын төсвийн хөрөнгө оруулалатаар хэрэгжүүлж буй Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд Борнуур, Баянчандмань, Сэргэлэн, Дэлгэрхаан суманд захиалагчийн техник хяналтаар ажиллаж холбогдох үүрэг даалгаврууд өгөв
- Нэгдсэн эмнэлгийн 50 ортой өргөтгөлийн барилгын үе шатны ажлуудад захиалагчийн техникийн хяналтаар ажиллаж холбогдох үүрэг даалгаврууд өглөө.
- Усан толио цэцэрлэгт хүрээлэнгийн гадна цэвэр усны шугам сүлжээ угсралтын ажил дууссан тоног төхөөрөмж угсралтын ажил, гадна тохижилтийн ажил дээр хяналтаар ажиллалаа.
- Дулааны станцын 1 –р хэлхээний шугам сүлжээний өөрчлөлтийн талаар Эрчим хүчний яам, зургийн компани, гүйцэтгэгч болон хангагч байгуулагуудтай газар дээр нь явж зургийн өөрчлөлтийг хийсэн.
- Дулааны станцын 2 –р хэлхээний шугамын өргөтгөл, шинэчлэлийн ажлын төсвийг магадлалаар дахин хянуулах тухай албан тоотыг Засаг даргаар батлуулан Эрчим хүчний сайдад хүргүүлсэн. Мөн орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажлын талаар гүйцэтгэгч Метаменежмент ХХК –тай энэ жил хийгдэх ажлын тоо хэмжээг баталгаажуулан албан бичгийг хүргүүлэв
- Жаргалант сумын тамгын газрын засварын ажил, спорт залны барилга угсралтын ажлуудад захиалагчийн техник хяналтаар ажиллаж үүрэг даалгаврууд өгөв.

### **ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

*Суурь судалгаа газрын мониторингийн чиглэлээр:*

Сумын фотомониторингийн хээрийн хэмжилтийг 8 дугаар сарын эхний долоо хоногт хийж, ургамлын бүрхэцийн зураг, ургамлын жинг газар дээр нь болон хатаасны дараах жинг харьцуулсан судалгааг хийж 260 цэгийн мэдээлэл тайланг мониторингийн мэдээллийн санд оруулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.

*Кадастрын чиглэлээр:*

Кадастрын мэдээллийн сангаар иргэдэд үйлчилж 67 иргэний өргөдөл, хүсэлтийн дагуу мэдээллийн санд бүртгэл хийж, кадастрын зургаар 125 иргэнд үйлчилсэн.

Шүүхийн шийдвэрээр эзэмшил, өмчлөлийн эрх түдгэлзүүлэх 5 бүртгэл хийсэн.

*Геодези, зураг зүйн ажлын хүрээнд:*

Төв аймаг цагдаагийн газраас ирүүлсэн 4-н албан бичгийн дагуу лавлагааг гарган хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн албан бичгээр ирсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар өргөдөл өгсөн 8 талбайд шүүлт хийж хариуг хүргүүлсэн. Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирсэн захирамжын дагуу “Байгаль ээж” сан ТББ-ын гүйцэтгэх захирал Т.Баярсайханы нэхэмжлэлтэй Төв аймаг Сэргэлэн сумын засаг дарга-д холбогдох захиргааны хэрэгт шинжээчээр ажиллаж дүгнэлтийг хүргүүлсэн. 2 иргэний өргөдөлийг судлаж хяналтын хэмжилт хийж хариуг хүргүүлсэн.

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР**

*Орон нутгийн өмчийн хүрээнд:*

”БЗОСК ОНӨААТҮГ-аас зарласан ”Түрээсийн орон сууц” барих төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан “Төв Цогт өлзийт” ХХК-ийн 70 хувийн гүйцэтгэлтэй барьж байгаа 40 айлын орон сууцанд аймгийн Засаг даргын 2023 оны 01/1204 тоот албан бичгийн дагуу Түрээсийн орон сууцанд хамрагдахыг хүссэн 340 иргэдтэй утсаар холбогдон, 30 %-ийг төлөөд, үлдэгдэл 70%-ийг ипотекийн зээлд хамрагдах болзолыг хангасан иргэдийн жагсаалтыг гаргаж, “Төв Цогт өлзийт” ХХК-ийн дансанд 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 540.0 сая төгрөгийг төвлөрүүлснээр барилгын ажил эрчимтэй явагдаж байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл (Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон, Төв, Улаанбаатар, Баянзүрх, Ховд, Хөвсгөл) багц №15 төв хадлангийн иж бүрдэл техник нийлүүлэх 230616/04-407 тоот

гэрээний дагуу трактор, тоног төхөөрөмжийг гэрээний 2 дахь заалтын хүрээнд Аймгийн Засаг даргын орлогчоор ажлын хэсэг байгуулсан захирамжийг гаргуулан Грийн Капитал ХХК-иас хүлээн авч Дэлгэрхаан, Бүрэн, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баян гэсэн 5 суманд хүлээлгэн өгсөн.

ТӨБЗГ-ын албан бичгийн хүрээнд сумдад албан тоот хүргүүлж, Орон нутгийн өмчид бүртгэлтэй ашиглагдахгүй байгаа барилга байгууламжийн судалгааг гаргуулан авч, нэгтгэн цаг хугацаанд хүргүүлсэн.

**Түрээсийн орон сууцны хүрээнд:** Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх, нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын график хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт 168.000,000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### **ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

Монгол улсад Мал эмнэлэг, үржлийн алба үүсэж байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд “Суффолк хонины шоу фарм, залуу малчдыг чадавхижуулах сургалт”-ыг залуу малчид болон хонины аж ахуй эрхлэх сонирхолтой иргэд, малчдыг хамрууллаа.

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг эртнээс хангуулах үүднээс аймгийн Засаг даргын А/574 тоот захирамжаар “Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө”-г 5 зорилт, 36 арга хэмжээтэйгээр батлуулан сумдад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

“Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолын дагуу Аймгийн Засаг даргын А/584 тоот захирамжаар “Сумын нөөц болон малчин, мал бүхий иргэдийн 2023 онд бэлтгэх хадлан, гар тэжээлийн төлөвлөгөө”-г сумдад хүргүүлэн ажилласан.

-Энэхүү төлөвлөгөөгөөр: Аймгийн аюулгүйн нөөцөд 250 тн өвс, 100 тн тэжээл

- сумын аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 50 тн тэжээл

- малчин, мал бүхий иргэд 153041.6 тн өвс, 9097.6 тн тэжээл, 51282 тн гар тэжээл, 9097.6 тн ногоон тэжээл бэлтгэнэ.

2022 онд 100 сая литр сүү, 2023 онд 110 сая литр сүү сааж зах зээлд нийлүүлсэн малчид, саальчид, фермер эрхлэгчид, хоршоодыг алдаршуулах “Төв түмний сүүн соёл”-Сүүн баяр арга хэмжээг ХХААХҮЯам, Монголын үхэр үржүүлэгчдийн нэгдсэн холбоотой хамтран зохион байгуулж, 20 сумын 200 гаруй малчид, саальчид, хоршоологчид, фермер эрхлэгчид оролцлоо.

“Төв түмний сүүн соёл”-Сүүний баяр 2023 арга хэмжээний хөтөлбөрийн дагуу “Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн” зохион байгуулж “Шилдэг саальчин”, “Саальчид дуулж байна”, “Нутгийн цай”, “Уламжлалт цагаан идээ”(өрөм, бяслаг, тараг эзэгий), “Шилмэл мал”(бух, гунж, бяруу), “Сүүн ашиг шим ихтэй үнээ”, “Зохион байгуулалттай сум” номиннациар шилдгүүдээ шалгарууллаа.

Аймгийн хэмжээнд Хадланд бэлтгэлийн нийт 60 салаа, 355 иргэн ажиллана.

- Том трактор 26

- Жижиг оврын трактор 64

- Автомашин 133

- Гар хадуур 137

- Тармуур 36

- Чиргүүл 61

- Хаман боогч 92 техникийн бэлэн байдал ханган ажиллаж байна.

**Газар тариалангийн хүрээнд:** Аймгийн Засаг даргын А/605 тоот захирамжаар ургацын урьдчилсан баланс тогтоох ажлын хэсгийг байгуулан тариалан бүхий 15 суманд 08 дугаар сарын 18-20 ны өдрүүдэд ажиллалаа.

Ургацын урьдчилсан балансаар: Үр тариа 60,3 га-аас 104,6 мянган тн, нэгжийн ургац 17,5 цн, улаанбуудай 52.2 мянган га-аас 91,8 мянган тн, нэгжийн ургац 17,8 цн, Төмс 11,4 мянган га-аас, 86,2 мянган тн, нэгжийн ургац 75 цн, хүнсний ногоо 3,2 мянган га-аас 32,4 мянган тн, нэгжийн ургац 103,1 цн, таримал тэжээл 32,1 мянган га-аас, 127,5 мянган тн, нэгжийн ургац 39,3 цн, тосны ургамал 36,6 мянган га-аас, 19,7 мянган тн, нэгжийн ургац 5,4 цн ургац тус тус хураан авахаар урьдчилсан дүн мэдээ гарсан.

Урьдчилсан балансаар гарсан ургацаа бууруулахгүй хаягдалгүй хураах зохилгоор орон нутгийн удирдлага, тариаланчид, эрдэмтэн багш, зөвлөх агрономичдыг оролцуулан үр



тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг Заамар суманд, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг Угтаалцайдам суманд тус тус зохион байгууллаа. Зөвлөгөөнд нийт 113 тариалан эрхлэгчид төрийн албан хаагчид хамрагдсан.

Ургац хураалтын бэлтгэл ажлын хүрээнд дутагдаж байгаа хүн хүчний судалгааг тариалан бүхий сумдын аж ахуйн нэгж иргэнээс нийт 1298 оюутан, цэргийн захиалга, Ургац тээвэрлэх зам, гүүрийн засварын захиалгыг 6 сумын 8 байршилд 55 км зам засварлах захиалгыг авч ХХААХҮЯаманд хүргүүлсэн.

#### **Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний хүрээнд:**

Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” төлөвлөгөөний дагуу ХХААХҮЯ-ны сайдын 2023 оны А/326 дугаар тушаалаар ЖДҮХС-аас аймгийн хэмжээнд 405.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр батлагдсан.

Тус төслийн материалыг 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 09.00 цагаас 2023 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 09.00 цаг хүртэл цахимаар хүлээн авч 2 аж ахуйн нэгжийн 2 төслийн материалын иж бүрдлийг шалган дараагийн шатанд шилжүүллээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ-с зохион байгуулсан “Хүнс, Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн чадавхижуулах” цахим сургалтад 24 сумын 24 мэргэжилтэн хамрагдлаа.

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн ангилал буурсан 13 сумын 25 иргэний зээлийн ангилалыг хэвийн ангилалд шилжүүлэн Монгол банкны лавалгаа мэдээллийн санд бүртгэлжүүллээ.

“Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадавхтай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл (ТА-10059 МОН)” -ийг хэрэгжүүлж, Хөшигийн хөндий, Шинэ Зуунмод хотын нийгэм, эдийн засаг, санхүү, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчин, гамшин уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал зэрэг салбар бүрийн судалгааны хүрээнд”Орон нутагт жижиг дунд бизнес эрхэлж байгаа болон бизнес эхлүүлж буй эмэгтэйчүүдийн бүлэг” бүлгийн ярилцлага уулзалт зохион байгуулж, Алтанбулаг, Зуунмод, Сэргэлэн сумын 12 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төлөөлөл хамрагдсан.

#### **СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн Зуунмод, Жаргалант, Батсүмбэр, Алтанбулаг сумдын 14 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг хүлээн авч бүтээгдэхүүн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулан ажилласан. Стандартын салбар сангийн үйлчилгээгээг 3 ААН, иргэнд үзүүлж 3 төрлийн стандартыг олгосон.

Тайлангийн хугацаанд хэмжлийн 1 төрлөөр 742 ширхэг хэмжих хэрэгсэл шалгаж баталгаажуулсан. Үүнд:

- ✓ Цахилгаан: Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээний харьяа Төв аймгийн Жаргалант салбарын ААН, айл өрхийн 1 болон 3 фазын 549ш электрон тоолуур, Зуунмод сумын айл өрхийн 1 фазын 193ш электрон тоолуурт ээлжит баталгаажуулалт хийсэн.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 22 сорьцыг шалгаж хүлээн авч 60 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс стандартын шаардлага хангаагүй сорьц, үзүүлэлт илрээгүй.

Эрүүл ахуйн хими, хор судлалын лаборатори нь 11 сорьцонд 27 үзүүлэлт / гүний ус 2 сорьц 14, хоол 5 сорьц 9, дотоод хяналтын 4 сорьц 4 үзүүлэлт/-ээр эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна. Үүнээс стандартын шаардлага хангаагүй сорьц, үзүүлэлт илрээгүй.

Эрүүл ахуйн нян судлалын лаборатори нь нийт 11 сорьцонд 33 үзүүлэлт гүний ус 11 сорьцонд 33 үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан. Үүнээс: Стандартын шаардлага хангаагүй сорьц, үзүүлэлт илрээгүй.

#### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

Орчны бохирдлын талаар: БОАЖСайдын 2023 оны 02, Аймгийн Засаг даргын 01 албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зам дагасан хог хаягдал, баяр наадмын дараах их цэвэрлэгээг хийлээ. Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/586 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт орж Төв аймгийн Заамар сумын нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхөрлөрийн үйл ажиллагаанд ажлын хэсэгтэй хамтран хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Мөн аймгийн Цагдаагийн газраас

2023 оны 08 дугаар сарын 13, 18-өдөр шилжүүлсэн Баянчандмань, Эрдэнэ сумдын нутаг зохих зөвшөөрөлгүйгээр агнагдсан 17 тооны тарваганы гомдол мэлдээлэлд 2304000577, 2334000595 дугаартай зөрчлийн хэрэг нээж зөрчил шалгах ажиллагаа явуулж байна.

*Усыг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд:* Усны тухай хуулийн 28 дугаар зүйл ус ашиглагчид олгох зөвшөөрөл, 30 дугаар зүйл ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавих шаардлага болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралт “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах” журмын хэрэгжилтэд хяналт тавьж Төв аймгийн Борнуур сумын ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж ажиллаа.

*Аялал жуулчлалын чиглэлээр:* Нүүдэлчдийн уламжлалт өв соёлыг хадгалан хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, орон нутгийн эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог дэмжих, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулсан “ХАТАН ТУУЛЫН БҮСГҮЙЧҮҮД” арга хэмжээнд Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баяндэлгэр, Лүн, Заамар, Эрдэнэ гэсэн 6 сумын 9 багийн 360 орчим эмэгтэйчүүд 10 төрлөөр өрсөлдөж, авьяас билэг, ур чадвараа дайчлан оролцож, шилдэгүүдээ тодрууллаа. Амралт, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хуулийн хэрэгжилтийг хангуулах, орчны бохирдол, ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх ажлыг Борнуур сумын Дугана хад ХХК, Удамт жонон ХХК, Ёл хад ХХК-ны амралтын газруудад хийж, баримт бичгийг шалгуулах тухай хугацаатай мэдэгдэх хуудас өгөв. Бусад суманд хяналт шалгалтын ажлыг үргэлжлүүлэх хийнэ.

### **УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

*Урьдчилан мэдээлэх талаар:* Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7,10 хоног тутмын цаг агаарын тойм гаргаж И-мэйл-ээр дамжуулж, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр, нарийвчилсан анхааруулах мэдээ 5 удаа, хоногийн анхааруулах мэдээ 7 удаа, нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ 16-ны өдөр, хоногийн сэрэмжлүүлэг мэдээг нийт 1 удаа их борооны сэрэмжлүүлэг мэдээг гаргаж И-мэйл-ээр дамжуулж, [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайт, TuvTsaguur page-д байршуулан ард иргэдэд үйлчилсэн байна.

*Байгаль орчны шинжилгээний лаборатори:* Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 08 дугаар сард хэмжилт хийгээгүй, техникч ээлжийн амралттай тул түр зогсоосон.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 08 дугаар сард Туул-Лүн, Шивэрт-Борнуур голуудын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанарт нь Туул-Лүн 373 uS/cm, Шивэрт-Борнуур 429 uS/cm гарлаа.

*Ус судлалын салбар:* Төв аймгийн нутаг дэвсгэрийн Туул, Сөгнөгөр, Шивэрт, Хэрлэн голуудад 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 08 дугаар сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн-Хонгон 168 см, Хэрлэн-Мөнгөнморьт 174 см, Туул-Алтанбулаг харуулд 611 см, Туул-Лүн харуулд 188 см, Туул-Заамар харуулд 239 см, Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 225 см, Шивэрт-Борнуур харуул 161 см тус тус байсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад усны түвшин Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуул 10-16 см бага, Туул-Алтанбулаг харуул 8 см бага, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 10-27 см их, Сөгнөгөр-Сөгнөгөр харуул 17 см их, Шивэрт-Борнуур харуул 31 см их байлаа. Хэрлэн-Мөнгөнморьт ус судлалын харуул үерийн түвшин даван үерлэсэн хэвээр байна. Иймд Сөгнөгөр, Туул, Хэрлэн голын сав, эрэг дагуу суурьшиж, нутаглаж буй малчид, тариаланчид, аж ахуйн нэгж байгууллага, ард иргэд, аялал зугаалгаар яваа хүмүүс үерийн аюулаас байнга сонор сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулж байна.

### **ДОЛОО:НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:**

Орон нутгийн эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, нүүдэлчдийн уламжлалт өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор “Хатан Туулын бүсгүйчүүд” эвэнт арга хэмжээг аймгийн Засаг даргын ивээл дор 2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Зуунмод сумын “Өв соёлын өргөө” цогцолборт зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Туул голын сав дагуу оршдог Баян-Өнжүүл, Баяндалгар, Лүн, Заамар, Эрдэнэ, Алтанбулаг сумын Сумт, Аргал, Алтан-Овоо, Замт багийн зэрэг 6 сумын 200 гаруй бүсгүйчүүд Сайхан цай чанах, Цагаан идээ боловсруулах, Ноос савж эсгий хийх, Үндэсний дээл урлах, Ширмэл ширэх, Дээс

томж эдлэл хийх, Гар урлал, Сайхан Монгол бүсгүй, Үндэсний хоол, Сумдын мэндчилгээ гэсэн 10 төрлөөр оролцлоо.

“Боловсролын шинэ сэргэлт-сургалтын байгууллагын менежмент” сэдэвт сургалтыг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран зохион байгууллаа. Тус сургалтад 41 цэцэрлэгийн эрхлэгч, 31 ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер 49, мэргэжлийн боловсролын байгууллагын захирал, менежер нийт 128 удирдах албан хаагч оролцлоо.

Мөн дотуур байрны багш нар хүүхэд хөгжил хамгааллын чиглэлээр, гадаад хэлний багш нар 5-6 ангид “Pearson” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Мэдээлэл зүйн багш нар Системийн шинэчлэлийн сургалтад хамрагдаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд төрийн өмчийн ЕБС-ийн 5, 6 дугаар ангид “Pearson English” англи хэлний сургалтын цогц хөтөлбөр хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан Зуунмод сумын Хүмүүн цогцолбор дунд сургууль дээр 5, 6 дугаар ангид хичээл заах Англи хэлний багш нарт сургалтыг амжилттай зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх удирдах зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар аймгийн ЭМС-ын өвөлжилтийн бэлэн байдал (халаалт, дулаан, урсгал засвар, 2023 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явц, гүйцэтгэл, үр дүн, 2024 оны хөрөнгө оруулалтын ажлын санал, шинээр тусгасан ажил, үйлчилгээ, аймгийн Нэгдсэн эмнэлгийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үр дүн, үр ашиг, иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулсан байдал, гүйцэтгэл үр дүн, салбарын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцлээ.

Аймгийн удирдлагууд салбарын үйл ажиллагааны үндсэн статистик үзүүлэлтийн хагас жилийн үнэлгээ, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллах, тулгамдаж буй асуудлууд, цаашид анхаарах, яаралтай шийдвэрлэх шаардлагатай аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн дээвэр, агааржуулалт, дотоод засвар үйлчилгээ, иргэдийн дунд бухимдал үүсгээд буй 13А маягтын талаар зөв ойлголт мэдээлэл өгөх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг чиглэл өглөө.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “Гэр” төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас орон гэргүй болсон болон зорилтот бүлгийн 27 сумын 81 өрхөд 5 ханатай иж бүрэн гэрийг гардуулж өглөө.

Холт интернэйшнл олон улсын байгууллагын хандивлагчид, БНСУ-ын Инчеон хотын Мичүхүл дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч нар “Аз жаргалын өргөө” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцаж өнгөт принтер, хяналтын камер, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан бичиг хэргийн хэрэглэгдэхүүнүүдийг хандивлалаа.

#### ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД:

Аймгийн хэмжээнд 2023 оны 07 дугаар сарын байдлаар 502 эх төрж өнгөрсөн оны мөн үеэс 49 тохиолдлоор өсч, 508 нярай бүртгэгдсэн. Жирэмсний хяналтад нийт 672 эмэгтэй үүнээс 700 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, эхний 3 сартай эрт хяналт 93.86% байна. Нийт 206393 хүнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 66871, амбулаторийн үзлэг 114692, идэвхтэй хяналтаар 15803 хүнд үзлэг хийсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 8560 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Эмнэлэгт 9697 хүн эмчлэгдэн нийт 71296 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7.4 байна. Аймгийн хэмжээнд нийт 298 нас баралт бүртгэгдэж, эмнэлгийн нас баралт 21.81%, хорт хавдрын нас баралт 66 тохиолдол буюу 22.15%, гадны шалтгаант нас баралт 56 буюу 18.79%-ийг эзэлж байна.

Алтанбулаг, Батсүмбэр, Сэргэлэн, Жаргалант суманд бүртгэгдсэн хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцлээ. Хуралд ЭМГ-ын ЭТҮХ-ийн дарга, мэргэжилтнүүд, АНЭ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч, Алтанбулаг, Батсүмбэр, Жаргалант, Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн дарга, холбогдох эмч нар цахим болон танхим хэлбэрээр нийт 37 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцож дүгнэлт, шийдвэр гарган ЭХЭМҮТ-ийн тандалт судалгааны албанд мэдээллийг хүргүүлж ажиллалаа.

УИХ, ДЭМБ, ЭМЯ хамтран зохион байгуулж буй Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентын VII чуулганд оролцогч, төлөөлөгчид Алтанбулаг, Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж буй анхан шатны тусламж үйлчилгээтэй танилцлаа.

Эмийн сангийн стандартын дагуу 26 сумын Эрүүл мэндийн төвийн эмийн эргэлтийн сан 2 талдаа дэлгэцтэй компьютер, бар код уншигч машин, баримт хэвлэгч авч ашиглаж эхэлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар төсөл нь дэмжигдсэн 5, шинээр тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн 4, тусгай зөвшөөрөл хүчингүй болгох 2 Эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг хэлэлцэн, шийдвэрлэж, ЭМГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын А/47 дугаар тушаалаар баталгаажуулж шийдвэрийг аймгийн Татварын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст илгээлээ.

Аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яам, Геронтологийн үндэсний төвтэй хамтран ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Төв аймагт настны цогц тусламж үйлчилгээ, эрүүл насжилтад бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх салбар дундын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, Нэгдсэн эмнэлэг, Ахмадын хороо, Ахмадын төрийн бус байгууллага, Өрхийн эрүүл мэндийн төвийн төлөөллүүдийг оролцууллаа. Мөн Баруун Зуунмод өрхийн Эрүүл мэндийн төв, Батсүмбэр, Борнуур сумын ЭМТ-д ажиллан ахмадууд болон сум орон нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, санал солилцлоо.

Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг, "SIGHT FOR ALL" ОУ-ын байгууллага, АШУҮИС, МУЗН-ын хамтарсан төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай нүдний үзлэг оношилгоо хийх 6150\$ үнэ бүхий зөөврийн 5 төрлийн багаж хэрэгслийг гардууллаа. Уг багцад нүдний уг дурандах, нүдний даралт хэмжих багажууд болон 1 удаагийн болон дахин ариутган ашиглах боломжтой хошуу, 2 төрлийн линз багтсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд БНСУ-ын Конги аймгийн Эрүүл мэндийн нийгэмлэг, Гангнам эмэгтэйчүүдийн эмнэлэгтэй хамтран 69 хүний бүрэлдэхүүнтэй баг аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр иргэдэд үзлэг, оношилгоо хийж, шаардлагатай эм, витаминаар үйлчиллээ.

АНЭ-т сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах хуваарийн дагуу Зуунмод сумын 4 цэцэрлэгийн 729 хүүхдийг үзлэг, шинжилгээнд хамруулан, зөвлөмж өгч ажиллалаа.

Мөнгөнморьт суманд малын гоц халдварт боом өвчин голомтлон гарч, хүний өвчлөл бүртгэгдэж мэргэжлийн байгууллагууд хорио цээр тавин тандалт судалгаа хийж иргэдийг зөвлөгөө, зөвлөмж, мэдээллээр ханган ажиллаж байна. Хүний боомын өвчлөл батлагдсан 35 настай 1 эрэгтэй Багануур дүүргийн Нэгдсэн эмнэлэгт эмчлэгдэж байна. 2 хүний сэжигтэй тохиолдол илэрч, давтан шинжилгээ хийгдэн, хариу хүлээгдэж байна. Нийт 8 айлын 57 бод мал хорогдсон.

Эрүүл мэндийн газрын Хяналт, шалгалтын хэлтсээс дараах хяналт шалгалт, үнэлгээг хийж, дүгнэлт шийдвэр гаргасан. Үүнд:

-Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн халдвар хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийж 51,2 % буюу их эрсдэлтэй;

-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран Батсүмбэр сумын “Цагаан нуга” хүүхдийн зулсангийн халдвар хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийж 13,2% буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Орон сууцны барилга 10, шатахуун түгээх станц 5, амралт жуулчны бааз 8, нийт 23 барилгын зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт гаргасан.

Халдварт өвчний сэжигтэй тохиолдол нийт 17 бүртгэгдсэн. Аймгийн хэмжээнд энтеровирус, суулгалтат халдварт өвчин зонхилж байна. Ковид-19 цар тахлын эерэг тохиолдол бүртгэгдээгүй.

Орчны эрүүл мэндийн лабораторид нийт 55 сорьцод 492 үзүүлэлтээр шинжилгээг гүйцэтгэн, хариуг баталгаажуулан хүргүүлсэн. Үүнд:

Химийн лабораторид: Ус түгээх цэгийн 25 унд ахуйн усанд 400 үзүүлэлтээр, АНЭ-ийн Гемодиализын аппаратны 1 усанд шинжилгээг гүйцэтгэсэн.

Нян судлалын лабораторид: Ус түгээх цэгийн 25 унд ахуйн усанд, Борнуур сумын цэцэрлэгийн 2, АНЭ-ийн диализын аппаратны 1, төв цэвэрлэх байгууламжийн бохир усны 2 сорьцод шинжилгээг 92 үзүүлэлтээр хийж гүйцэтгэсэн

ЭМЯ, СЭМҮТ, НЭМҮТ-с “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд нөлөөллийн аяны” хүрээнд 6 төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол (донтолт, архи тамхины хэрэглээ, мансууруулах бодисын хамаарал, стресс ядаргаа) олгох сургалтыг зохион байгуулсан. Цахим онлайн хичээлийн бичлэг 5, Teaser бичлэг 7, постер зураг 10 зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудаст байршуулан, иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Төв аймгийн залуус ТББ-аас жил бүр зохион байгуулдаг "ШИДЭТ ЦҮНХ-2023" Зөв үйлсийн аянд аймгийн Нэгдсэн эмнэлэг нэгдэн, 720,000 төгрөгийн хандив хүлээлгэн өглөө.

Тарваган тахал, Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг иргэдэд цахимаар болон гарын авлага материал 220 ширхэгийг түгээсэн.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХҮРЭЭНД:

ЭМДЕГ-тай гэрээт 75 Эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 9,5 тэрбум төгрөгийн 109269 гүйцэтгэлд хяналт хийж, 1379 гүйцэтгэлийн 228 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, зөвлөмж хүргүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн, ЭМДЕГ-т хүргүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газарт 12 иргэний ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй авсан тусламж үйлчилгээний судалгааг нэгтгэн хүргүүлж ажиллалаа.

ЭМДЕГ-тай гэрээт аймгийн 27 сумын Эрүүл мэндийн төвтэй нэмэлт гэрээ байгуулан ЭМДЕГ-ын Худалдан авалт, гэрээлэлтийн газарт хүргүүлсэн.

### ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

Жаргалант сумын ЕБС-ийн харьяа Хүүхдийн хөдөлмөр зуслангийн үйл ажиллагаа аймаг, орон нутгийн санхүүжилтээр байгуулагдаж 2023 оны 08 дугаар сарын 19-ний өдөр нээлтээ хийн 1 дүгээр ээлжийн хүүхдүүдээ хүлээн авлаа.

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/108 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхдийн эрхийг хангах чиглэлээр тусгагдсан зорилтуудыг эрчимжүүлэх, хүүхдэд тулгамдаж буй хүндрэлтэй асуудлуудыг сонсох, тэдний оролцоотойгоор хамтран шийдлийг гаргах, хүүхдийн үзэл бодол, дуу хоолой, санал санаачилгыг шинээр боловсруулах бодлого шийдвэрт тусгах, хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагуудын сайн туршлагыг түгээх зорилго бүхий “Хүүхдийн оролцооны үндэсний чуулган”-ыг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Төрийн ордонд, 08 дугаар сарын 23-ны өдөр Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборт зохион байгуулагдаж чуулганд аймаг, орон нутгаас 29 хүүхэд оролцлоо.

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, аливаа асуудлаар шийдвэр гаргахад өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн, тэдний хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулж буй Монголын Хүүхдийн Зөвлөлийн Майхант цугларалт 08 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд Төв аймгийн Батсүмбэр сумын "Скаут кемп" зусланд зохион байгуулагдаж Төв аймгийн Хүүхдийн Зөвлөлийн төлөөлөгч 9 хүүхэд амжилттай оролцлоо.

“Хүүхдийн тусламжийн-108” дугаарын утсанд 08 дугаар сарын байдлаар нийт 10 дуудлага мэдээлэл ирснээс 3 дуудлагыг бүрэн шийдвэрлэж, хяналтад 7 дуудлага байна.

Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:

“Олон улсын аавуудын өдөр”-өөр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Монголын ГБССН-ийн Төв аймаг дахь салбар, хөгжлийн төв, ТБС телевизтэй хамтран “Баярлалаа ааваа” өдөрлөг зохион байгуулж, Зуунмод сумын 5 гэр бүл оролцсон.

Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан “Хамтдаа урагшилья” залуучуудын сарын аяныг аймгийн 27 сумын хэмжээнд өрнүүлэн ажиллаж байна.

“Хүний эрхийг дээдэлсэн нийгэм цогцлооход залуусын бүтээлч хамтын оролцоо” Залуучуудын хөгжлийн үндэсний есдүгээр чуулганыг угтаж, ТБС орон нутгийн телевизтэй хамтран “Залуусаа сонсьё” нээлттэй ярилцлага зохион байгуулж, Залуучуудын үндэсний чуулганд Төв аймгаас 5 залуусын төлөөлөл оролцлоо.

“Өөртөө хэрэггүй зүйлээ бусадтай хуваалцъя” уриатай сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл, цүнх, сурах бичиг, гутал, зэргийг бусдад үнэгүй өгөх, солилцох, хандивлах “Хуучирдаггүй хуучин хувцас” өдөрлөгийг 2023 оны 08 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгууллаа.

### БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өлзийт нуурын шагайн тойром” харвааг 2023 оны 08 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Баянцагаан суманд зохион байгуулж 12 багийн 96 харваач оролцлоо.

Төв аймгийн сум, сургуулиудаар тойрон уламжлал болгон зохион байгуулагддаг чөлөөт бөхийн техник-тактик, ББТХ, ББТХ-ийн зуны нэгдсэн бэлтгэл-цугларалтын хоёрдугаар шат Батсүмбэр суманд амжилттай болж Японы Меи мужийн Цү хотын Ичиши клубын 16 тамирчин дасгалжуулагч багш Ёшида Хэдетошигийн хамтаар хүрэлцэн ирж манай чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн 35 тамирчинтай хамтарсан бэлтгэлийг 2023 оны 08 дугаар сарын 06-20-ны өдрүүдэд хийлээ.

Төв аймгийн Баянөнжүүл сумын харьяат Дэлхийн аварга цолыг анх удаа эх орондоо авчирсан МУГТ Д.Дэмбэрэл, Баянцагаан сумын харьяат МУГД Л.Жамъянсүрэн нарын нэрэмжит тэмцээн байт харвааны олон улсын тэмцээн 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Зуунмод хотноо амжилттай зохион байгуулагдаж 18 багийн 80 тамирчин оролцлоо.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Нисэх загварын спортын Дэлхийн цомын хоёр тэмцээн 2023 оны 08 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж "Zuun bileg cup" Дэлхийн цомын тэмцээнд Монгол, Хятад, Япон улсын нийт 30 гаруй тамирчид өрсөлдөж, Төв аймгийн "Залуу зохион бүтээх төв"-ийн тамирчин Н.Номин Алтан медаль хүртэж Дэлхийн цомын эзэн боллоо.

2023 оны Монгол Улсын аварга, Хүүхдийн спортын VII их наадмын аварга Төв аймгийн Төв-Арж багийн тамирчин Баттогтохын Чулуун-Эрдэнэ Зүүн Азийн залуучуудын наадмаас хүрэл медаль хүртлээ.

Монголын дугуйчдын олон өдрийн 24 дэх удаагийн "TOUR DE MONGOLIE 2023" уралдааныг Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 2023 оны 08 дугаар сарын 18-аас 1-р гараа 15км-ын уралдаан Төв аймаг-Нисэхийн замд, 2-р гараа Төв нисэхийн замд 120 км, 3-р гараа, Алтанбулаг сумын замд 130 км, 4-р гараа Эрдэнэ сумын замд 150 км, 5-р гараа Баян сумын замд 160 км, 6-р гараа Зуунмод суманд 150 км-ын уралдааныг зохион байгуулж 18 байгууллагын 89 тамирчин оролцлоо.Энэ удаагийн тэмцээнд манай дугуй өсвөрийн шигшээ багийн тамирчид 1 алт, 5 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ.

### СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 183 дугаар тогтоолын дагуу 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан олон улсын тодотголтой "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Налайх дүүргийн "Тайж Хайрхан"-ны бэлд 11 сумын 40 оролцогч оролцлоо.

Уг фестивалд Монгол туургатан театрын 5 уран бүтээлч, өвлөн уламжлагч 17-73 насны 36 өвлөн уламжлагч оролцлоо. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг соёлын биет бус өвийн 7 ай савын 362 төрөл зүйлтэй нэг дор танилцах, соёл уламжлалаа дээдлэн хүндэтгэж, соёлын биет бус өвийг цаашид хамгаалах, өвлөн уламжлах, суралцах зэрэг оюуны соёлыг түгээн дэлгэрүүлсэн наадам болж өндөрлөлөө.

Тус фестивалд 21 аймаг, нүүдлийн соёл иргэншил бүхий гадаад улс орны БНХАУ-ын ӨМӨЗО, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Казахстан, БНКиргистан, БНСУ, ОХУ-ын Буриад Улс, ОХУ-ын Халимаг Улс, Саха улс, Тува, Турк, Юнеско болон олон улсын байгууллагын өвлөн уламжлагч, зочид төлөөлөгчид, 1100 гаруй оролцогч нүүдэлчид хуран чуулснаас Төв аймаг амжилттай оролцож, Соёлын өвийн орон зай, бүтээлч үйлдвэрлэл, уламжлал шинэчлэл, баялаг байдал, соёлын биет бус өвийн олон төрлийг түгээн дэлгэрүүлэх, илэрхийлэх хэлбэр, язгуур соёлоо дээдэлж, зохион байгуулалттай, таниулан сурталчилсан "Шилдэг зохион байгуулалт"-тай 5 аймгийн нэгээр шалгарч батламж, цом гардаж авсан.

### Монгол туургатан театр:

2023 оны 08 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд "Төв түмний соёл" сүүний баяр-2023 арга хэмжээг аймгийн Засаг даргын тамгын газар, ХХААГазартай хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээний нээлт болон хүндэтгэлийн арга хэмжээнд урлаг, уран сайхны үйлчилгээ үзүүлээ. Мөн 08-р сарын 27-нд "Саальчид дуулж байна" дууны тэмцээнийг шүүж, зохион байгуулан оролцсон.

### Музейн ажлын хүрээнд:

МУ-ын Засгийн Газрын 2023 оны 183 дугаар тогтоол, МУ-ын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газрын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/253 тоот албан бичиг, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах удирдамжийн дагуу Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэр "Тайж" хайрхны бэлд 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.

Тус наадамд Аймгийн Музей нь гар урлалын үзэсгэлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэл болон соёлын биет бус өвийг сурталчлан таниулах арга ажиллагааны отогуудыг хариуцан ажилласан. Гар урлалын үзэсгэлэн болон соёлын бүтээлч үйлдвэрлэлээр 6 сумдын (Алтанбулаг, Архуст, Баянчандмань, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Зуунмод) 13 урчуудын 115 бүтээлээр амжилттай оролцлоо.

Монголын Урчуудын Эвлэлийн Төв аймаг дахь салбараас санаачлан 2023 оны 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Керамик урлагийн уран бүтээлчдийн туршлага солилцох, олон нийтэд сурталчлан таниулан "Олон улсын симпозиум" үзэсгэлэнг Зуунмод амны Манзушир дахь байгаль, түүх соёлын дурсгалт газрын гадна талбайд зохион байгууллаа.

Энэхүү үзэсгэлэнд 24 мэргэжлийн уран бүтээлч, 50 гаруй сонирхогч зураач нарын 80 гаруй бүтээл тавигдаж иргэдэд соёл гэгээрийн үйлчилгээ хүргэхэд дэмжиж хамтран ажилласан.

Нийтийн номын сан:

Аймгийн Нийтийн номын сан нь 2023 оны 08 дугаар сард танхимаар 96 байнгын уншигч, 60 ном олгож уншуулсан ба үүнээс 26 эрэгтэй, 70 эмэгтэй уншигч үйлчлүүлсэн байна.

“Цахим мэдээллийн танхим”-аас уншигч хүүхэд залуучууд, иргэдэд зориулан Номын сангийн үйл ажиллагаа, цахим сан хөмрөгийн сурагчдын заавал унших ном, үлгэр болон 11 мэдээ мэдээллийг Нийтийн номын сангийн Facebook page цахим хуудсанд байршуулан олны хүртээл болгож 1873 хандалт авлаа.

Байгууллагын дээврийн их засварын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 10-18-ны хооронд “Дөрвөн лхагва” ХХК хийж гүйцэтгэсэн.

Сумдын соёлын төв:

Алтанбулаг, Аргалант, Архуст, Баян, Баяндэлгэр, Борнуур, Бүрэн, Жаргалант, Лүн, Өндөрширээт, Угтаал, Батсүмбэр сумдын соёлын төвүүд 4 төрлийн 58 удаагийн арга хэмжээнд 3200 орчим иргэдийг хамруулж ажилласан байна. Номын сангийн үйлчилгээг 600 гаруй иргэнд үзүүлж, 1242 номын цахим болон уншлагын үйлчилгээг үзүүлснээс байнгын уншигч 149 иргэн байна.

Угтаал-Цайдам суманд 08 дугаар сарын 12,13-нд Угтаал дартс клубээс зохион явуулсан дартсын нээлттэй тэмцээнийг зохион байгуулж, нээлтийн арга хэмжээнд урлаг, уран сайхны үйлчилгээгээр нийт 120 иргэнд хүрч үйлчилсэн.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны 08 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1888 иргэнд 4278,3 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1224 иргэнд 1260,7 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 16 иргэнд 19,2 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 1204 иргэнд 496,4 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9959 эхэд 1274,1 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 4290 ахмад настанд 338,7 сая төгрөг, Насны хишиг 6034 иргэнд 965.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 884 иргэнд 93,4 сая төгрөг, жирэмсэн 1025 эхэд 174,6 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж 4271 иргэнд 1388,3 сая төгрөг, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 315 иргэнд 335,2 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 16 иргэнд 32 сая төгрөг тус тус олголоо.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүүхдийн мөнгөний талаар:

Хүүхдийн мөнгөтэй холбоотой журам чиглэлийн талаар утсаар болон биечлэн 90 гаруй иргэдэд мэдээлэл өгч, шинэ төрсөн 84 хүүхдийг мэдээллийн санд бүртгэн нийт 34124 хүүхдэд 2747,1 сая төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олголоо.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 1 өрхийн 4 иргэний үйлчилгээг сумын АДЗ-ийн шийдвэрт үндэслэн зогсоож, 431 өрхийн 1136 иргэн 1201 хүүхдэд 182,1 сая төгрөгийн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийллээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сан:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Job программд 08 дугаар сард 5 ажил олгогч, 32 ажил хайгч иргэн шинээр бүртгүүлж, өссөн дүнгээр 373 ажил олгогч, 742 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байна. Дээрх бүртгэлтэй ажил олгогчдоос 171 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогчид бөгөөд 202 нь аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Тайлант хугацаанд шинээр 48 ажлын байр бий болсон бөгөөд үүнээс түр 15, улирлын 15, байнгын шинэ ажлын байр 18 байна. Өссөн дүнгээр аймгийн хэмжээнд нийт 546 шинэ ажлын байр бүртгэлтэй байгаагаас байнгын 368, улирлын 30, түр 148 ажлын байр бий боллоо. Нийт 8 ажил олгогчийн 38 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг энэ сард хүлээн авч 43 иргэнийг тохирох ажлын байранд зуучиллаа. Өссөн дүнгээр нийт 1246 ажлын байрны захиалга ирснээс 900 гаруй ажлын байрны захиалга нь гадаадаас ажиллах хүч авахтай холбоотой бөгөөд идэвхтэй 332 ажлын байрны захиалгын шаардлагад тэнцэх 273 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд:

Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэн Батсүмбэр сумын 7 өрхийг 28 толгой бод, Борнуур сумын 10 өрхийг 51 толгой бод, Жаргалант сумын 5 өрхийг нийт 25 толгой бод, нийт 22 өрхийг 104 толгой малаар малжуулж малыг хүлээлцлээ. Малжуулах арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санаас 520,0 сая төгрөгийг зарцууллаа.

Монголын удирдлага шинэчлэлийн академи ТББ-тай хамтран малжуулах арга хэмжээнд хамрагдсан 115 малчинд “Малчдын сургалт”-ыг зохион байгуулж мал маллах арга ухаан болон орлого зарлагыг зөв төлөвлөж, бизнесийн орлогоо нэмэгдүүлэх арга ухаан, малын үржлийг зөв тохируулах, ашиг шимийг хэрхэн тооцох талаар зөвлөгөө өглөө.

Мөн Сонор эдюкэшин сургалтын төвтэй хамтран Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний болон төгсөлтийн аргачлал арга хэмжээнд хамрагдаж буй зорилтот бүлгийн ажил олоход хүндрэлтэй, ажилгүй 85 иргэнд хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан :

Тайлант хугацаанд 109 иргэний 25888.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 367 иргэний 402066.4 мянган төгрөгийг төвлөрүүлээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Жирэмсэн амаржсаны тэтгэмж 136 даатгуулагчид 302.0 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 104 даатгуулагчид 20.6 сая, ажилгүйдлийн тэтгэмж 65 даатгуулагчид 205.8 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 36 иргэнд 72,0 сая төгрөг, Үйлдвэрлэлийн ослын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг 7 иргэнд 6.1 сая төгрөг, Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 16808 тэтгэвэр авагчдад 10,5 тэрбум төгрөгийн тэтгэврийг тус тус олголоо.

Хуримтлагдсан өрийг барагдуулах ажлын хүрээнд 44 ажил олгогчийн 485 сая төгрөгийн өрийг барагдуулахаар албан шаардлага хүргүүлж, 142 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн банкин дахь дансны зарлагын гүйлгээг хаан, 14 ажил олгогчийн 399,3 сая төгрөгийн өрийг барагдуулахаар харилцан гэрээ байгууллаа.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХҮРЭЭНД

Аймгийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 1985 хүүхэд элсэн суралцах төлөв байна. 1-р ангийн элсэлтийг 3 хэлбэрээр зохион байгууллаа. Үүнд:

- e-mongolia Вэб <https://e-mongolia.mn/home>

- Гар утасны аппликэйшн

Сургуулийн элсэлтийн комисст хандах бүртгэлийг баталгаажуулсан. Сургууль бүрийн элсэлтийн комисс бүлэг хуваарилалтыг хийж байна.

Аймгийн хэмжээнд монгол хэл бичгийн шалгалтыг 08 дугаар сарын 19-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Монгол хэл бичгийн шалгалтад 57 шалгуулагчаас 30 шалгуулагч орсон. ирц 52,6% байна.

Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмжийг таниулах, түгээн дэлгэрүүлэх сургалтад БШУГ-ын дарга 14 мэргэжилтэн, 41 цэцэрлэгийн эрхлэгч, 30 сургуулийн захирал, 4 мэргэжлийн боловсролын захирал, АБНТБ төвийн захирал, менежер нийт 92 хүн, Боловсролын ерөнхий хуулиа хүлээн авах арга хэмжээнд оролцлоо.

Албан бус Насан туршийн боловсролын талаар

Боловсролын ерөнхий газар Насан туршийн боловсролын хэлтсээс 21 аймгийн 130 багш, удирдах ажилтны “Хувьсаж буй боловсрол Насан туршийн суралцахуй” “Боловсролын шинэ сэргэлт сургалтад 2023 оны 08 дугаар сарын 23-25-ны өдөр УБ хотод зохион байгуулагдлаа. Төв аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилт болон үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлон гаргаж 27 сумын нэгжийн багш нарт хүргүүлэн ажилласан.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР